

Сургаал ба Гэрээ 20 дээрх Баптисм ба ариун ёслолын тухай сургаалууд

1-р хэсэг: Баптисмд тавигдах шаардлагууд

Сургаал ба Гэрээ 20:37-г уншаад, баптисмын шаардлагыг хангахын тулд юу хийх ёстойг олж мэд.

Ойлгохгүй үг гарвал тухайн үгийн тодорхойлолтыг хараарай. Доорх зайд баптисмын шаардлагуудыг жагсаан бич. Та зарим шаардлагыг өөрийн үгээр бичиж болно.

- Эдгээр шаардлага нь Их Эзэний тухай болон биднийг гэсэн Түүний хүслийн талаар юу зааж байна вэ?
- Баптисм хүртсэнийхээ дараа ч эдгээр шаардлагыг санадаг байх нь бидэнд хэрхэн тустай байх вэ?

37-р шүлэг дээрээс хоёр эсвэл гурван шаардлагыг сонго. Уг шаардлагуудад нийцүүлэхийг тууштай хичээх нь танд Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёртой илүү адил болоход хэрхэн тустай байх талаар ярилц.

2-р хэсэг: Баптисмын дараа тавигдах шаардлагууд

Сургаал ба Гэрээ 20:68–69-ийг уншаад, баптисм хүртсэний дараа Их Эзэн биднээс юу хийхийг хүсдэгийг олж тогтоо.

- Баптисм хүртсэнийхээ дараа бид Их Эзэнд зохистой байдлаа хэрхэн харуулах талаар та 69-р шүлгээс юу сурсан бэ?

69-р шүлэг дэх “бурханлаг алхаа хийгээд яриа” гэсэн үг хэллэгийг тэмдэглэх талаар бодож үз. Хүн “бурханлаг алхаа хийгээд яриа”-г Бурханд нийцдэг үйлдэл, зан байдал, үг хэлээрээ дамжуулан харуулж чадна.

- Их Эзэн баптисм хүртсэний дараа “бурханлаг алхаа хийгээд яриа”-г харуулахыг Өөрийн Сүмийн гишүүдээс хүсдэг ямар шалтгаан байдаг гэж та бодож байна вэ?

Бид амьдралдаа “бурханлаг алхаа хийгээд яриа”-г харуулахад тусалж болох ядаж гурван тодорхой жишээг ярилц. Та энэ шаардлагуудыг өөрийн амьдрал дээр хэрхэн харуулахыг хичээж байсан арга замуудынхаа талаар жишээ хуваалцаж болно.

3-р хэсэг: Ариун ёслолоос хүртэх

Сургаал ба Гэрээ 20:75-ыг уншаад, ариун ёслолын тухай Их Эзэний өгсөн зааврыг олж мэд.

- Их Эзэн яагаад биднийг долоо хоногт нэг удаа цугларч ариун ёслолоос хүртэхийг хүсдэг гэж та бодож байна вэ?

77, 79-р шүлэгт ариун ёслолыг гүйцэтгэх үед санваартнуудад өгөхийг Их Эзэнээс зааварласан залбирлууд багтсан байдаг. Бид ариун ёслолоос хүртэхдээ, баптисм хүртэж, гишүүнээр батлуулах үедээ байгуулсан гэрээгээ шинэчилдэг. Бид гэрээгээ сахиж, өдөр бүр наманчилснаар баптисмаар ирдэг цэвэршүүлэлт, адислалуудыг олж авдаг.

Сургаал ба Гэрээ 20:77, 79-р шүлгүүдийг уншаад, ариун ёслолоос хүртэхэд Их Эзэний бидэнд өгдөг амлалт мөн бид ямар амлалт өгдөг тухай хайж ол. Тэдгээр амлалтыг судрууд дээрээ тэмдэглэхийг бод.

- Бид Есүс Христийн нэрийг өөрсөд дээрээ авахад бэлэн байгаагаа хэрхэн харуулах вэ?
- Бид Бурханыг хайрладаг гэдгээ ямар арга замаар харуулж болох вэ?

Ариун ёслол нь Аврагчийн бидэнд зориулсан хайр, нигүүлслийг хэрхэн харуулдаг вэ?